



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Мандах сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/12/СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

(Хотын нэр оруулах)

2019 он

Тэргүүлэх аудитор:Ч.Ариунаа

Утас: Цахим хаяг:

Аудитын менежер:

Утас: Цахим хаяг:

Ахлах аудитор:Ц.Лүндэгмаа

Утас: Цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1.	Оршил.....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар	8
2.8.2	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар.....	10
2.8.2.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	11
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	11
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	12
2.11.	Шилэн дансны мэдээлэл	13
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	13
2.13.	Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:	13
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	14
3	Менежментийн захидал	15
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	17

1 Аудитын гэрчилгээ



МАНДАХ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Н. ОТГОНБАЯР ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мандах сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Мандах сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Мандах сумын Засаг даргын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Мандах сумын Засаг дарга Төсвийн тухай хуулийн (54 дүгээр зүйлийн 54.3/26 дугаар зүйлийн 26.1)⁷-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Мандах сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч сумын засаг дарга Отгонбаяр-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2,3-д заасны дагуу Мандах сумын Засаг дарга 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мандах сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.03.18-наас 2019.03.22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.03.22-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-ын ахлах аудитор Ц.Лүндэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Мандах сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2019.03.01-ны өдрийн 5/67 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Мандах сумын Засаг дарга талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Мандах сумын Засаг дарга нь “Төрийн үйлчилгээг иргэдэд ил тод, чанартай шуурхай хүргэх цомхон чадварлаг мэргэжлийн тогтвортой ажлын албыг бүрдүүлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Мандах сумын Засаг дарга удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний (6) байгууллага, нэгж 2018 оны санхүүгийн тайландаа аудит хийж баталгаажуулахаас (6) байгууллага аудитад хамрагдсан байна.

Төрийн аудитын байгууллагаас Мандах сумын Засаг дарга эрх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Түүвэрлэсэн	Итгэл үзүүлсэн	Гэрээгээр хийлгэсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	4	2			
2	ТБӨӨААН					
	Дүн	4	2			

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Мандах сумын Засаг дарга мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Мандах сумын Засаг дарга санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Мандах сумын Засаг дарга санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн програм хангамж ашигладаггүй байна.

Мандах сумын Засаг дарга дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Мандах сумын Засаг дарга бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогын 2 хувиар сонгов.

Орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь нийт хөрөнгийн дүн өндөр байгаатай холбоотой юм.

Мандах сумын Засаг дарга 2018 оны нийт орлого 2538.3 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 50.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн материаллаг биш боловч цаашид санхүүгийн тайлан, тодруулгад материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй зарим асуудлыг толилуулж байна.

Мандах сумын Засаг дарга болон төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагчийн хэмжээнд 31.9 сая төгрөг, төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэмжээнд 10.2 сая төгрөг, нийт 42.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна.

Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлыг хэрхэн ангилж, шийдвэрлэсэн байдлыг энэ тайлангийн 2.13-т нэгтгэсэн байдлаар үзүүлэв.

Асуудлыг өмнөх түвшинд хийсэн аудитын явцад гарсан асуудал, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад түүвэрт хамрагдсан асуудлаас илэрсэн асуудал гэсэн ангиллаар үзүүлэв.Үүнд:

2.8.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

Асуудал 1: Зардал

1. Ерөнхий боловсролын сургууль:Тайлант хугацааны хоол хүнсний зардалд батлагдсан 25.9 сая төгрөгийн худалдан авалтыг хийхдээ харьцуулалтын

аргыг ашиглахгүйгээр шууд гэрээ байгуулан худалдан авалт хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.2 дахь заалт, сангийн сайдын 2013 оны 1 дүгээр тушаалаар баталсан Цахим тендер зохион байгуулах журам, Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 9.2 дахь заалт, Засгийн газрын Босго үнэ шинэчлэн батлах тухай 2013 оны 68 дугаар тогтоолыг тус тус зөрчсөн байна.

Худалдан авалтын зарим ажил гүйлгээ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан НХМ-ТМ-5 маягтаар гүйлгээ хийгдээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.5, 13.7 дугаар заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдэл: Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах албан шаардлага өгсөн.

2. Эрүүл мэндийн төв: Цалингийн зардлын хэмнэлтээс 2018 оны 12 сард 2.9 сая төгрөгийг татварын хэлтэст шилжүүлж авлагаар бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдэл: Төсвийн хэмнэлт 2.9 сая төгрөгийг тус байгууллагын 2019 оны цалингийн сангаас төсвийн орлого болгож төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

3. Соёлын төв: Цалин хөлс бодож холбогдох суутгал суутгахдаа хууль журамд нийцүүлээгүй байна.

Шийдэл: 0.1 сая төгрөгийн зөрчилд холбогдох хууль эрх зүйн актыг мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

Асуудал 2: Балансын данстай холбоотой асуудал

1. Хүүхдийн цэцэрлэг: Уртын-Уул ХХК-аас 3.0 сая төгрөгийн авлага тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтыг зөрчиж байна.

Шийдэл: Төсвийн тухай хуулийн 6.4.8 “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн зарчмыг мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

2. Сургууль: Санхүүгийн байдлын тайлан дахь НДШ-ийн өглөгийн эхний үлдэгдэл нь НДШ-ийн тайлангийн эхний үлдэгдлээс зөрүүтэй тайлагнагдсан байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20.2.5, 20.2.6 дахь заалт болон Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтыг зөрчиж байна.

Шийдэл: Тайлант хугацааны эцэст харилцагч байгууллагатай үлдэгдлийн тулган баталгаажуулалт хийж байх зөвлөмж өгөв.

3. Хүүхдийн цэцэрлэг: НДШ-ийн тооцоогоор өр авлагагүй боловч өглөгтэй гэж тооцоо нийлэн санхүүгийн тайланд өглөг тайлагнасан.

Шийдэл: Төсвийн тухай хуулийн 6.4.8 “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн зарчмыг мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

4. Сургууль: ХЧТА Тэтгэмжийн мөнгөнөөс ХХОАТ-ын 10 хувь суутгаж байгаа нь гарт олгох тэтгэмжийг дутуу олгож байна. Энэ нь Нийгмийн даатгалын сангаас

олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 19.2, 29 дүгээр заалт, Хувь хүний орлогын татварын тухай хуулийн 16.1.1 дэх заалт, 22.23 дугаар заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдэл: Тэтгэмжийг олгохдоо мөрдөгдөж байгаа хууль эрх зүйг сайн судлах зөвлөмж өгөв.

5. **Хүүхдийн цэцэрлэг:** Хууль тогтоомжийн дагуу олгож байгаа ХЧТА тэтгэмжийг дутуу олгосон байна.

Шийдэл: Хүн амын орлогын татварын тухай хуулийн 16.1.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

Асуудал 3: Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт

Сургууль: Төсвийн хөрөнгөөр худалдан авалт хийхдээ зарим ажил гүйлгээний анхан шатны баримтад худалдан авалтыг баталгаажуулсан Е баримт хавсаргаагүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан Өмчийн бүх хэлбэрийн ААНБ-д нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг хөтлөх зааврыг тус тус зөрчиж байна.

Шийдэл: Е баримтыг худалдан авалт хийсэн ажил гүйлгээ бүрд анхан шатны нотлох баримтаар авч баримт бүрдүүлэлтийг сайжруулах гэсэн зөвлөмж өгөв.

2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Мандах сумын Засаг даргын Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 13 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.

Засгийн газрын тусгай сангийн эрсдэлийн үнэлгээний дүнд ОНХС-нд аудитын 2 чиглэлээр 9 горим сорил гүйцэтгэж үнэлж асуудлуудыг алдаа зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ. Мөн СХС-ийн хүрээнд аудитын аудитын 3 чиглэлээр 3 горим сорил гүйцэтгэж үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 1 асуудлыг алдаа зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	1.1	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	1	9.1	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	4	10.2	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Аудитын чиглэл: Өмнөх аудит болон зөвлөмжийн биелэлт

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөс зээл авсан 2015 онд төлж дуусах хугацаатай 1 иргэний 993.7 мянган төгрөгийн, 2017-2018 онд зээлийн хугацаа дууссан 2 иргэний 8142.5 мянган төгрөгийн, нийт 9136.2 мянган төгрөгийн авлага байна.

Энэ нь ЗГ-ын 2016 оны 153 дугаар тушаалаар баталсан СХС-ийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын 5.2. Сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг сумын Засаг дарга хариуцан арилгана. 5.3.2. сангийн үйл ажиллагаанд улирал бүр хяналт шалгалт хийж, дүнг тухайн сумын нийт иргэдэд мэдээлж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэх гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Шийдэл: Сум хөгжүүлэх сангаас зээл авсан, хугацаандаа төлбөрөө барагдуулаагүй иргэдийн төлбөрийг барагдуулах ажил зохион байгуулах, зээл төлөх хугацаа хэтэрсэн иргэдийн асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх, сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд улирал бүр хяналт шалгалт хийж нийт сумын иргэдэд мэдээлэх, ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх албан шаардлага өгөв.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Мандах сумын Засаг дарга чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 7 хөтөлбөр, 24 арга хэмжээнд зориулан 1,381,636.4 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн орлогын нийт гүйцэтгэл 1,391,182.9 мянган төгрөг буюу 100.7 хувь, зардлын нийт гүйцэтгэл 1,399,340.6 мянган төгрөг буюу 92.9 хувьтай байгаа нь Сум хөгжүүлэх сан, нөхөн сэргээлтийн сангийн зарлагаас шалтгаалжээ.

Төсвийн орлого, зардлын төлөвлөгөөний биелэлтийг харъяа байгууллагаар нь авч үзвэл :

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Орлого:	1,381,636,400.00	1,391,182,957.44	-9,546,557.44
Татварын орлого	68,702,500.00	72,094,411.44	-3,391,911.44
Татварын бус орлого	1,171,000.00	1,189,500.00	-18,500.00
Санхүүгийн дэмжлэг	255,515,300.00	255,515,300.00	0.00
Орон нутгийн хөгжлийн сан орлогын шилжүүлэг	86,904,000.00	86,904,000.00	0.00
Тусгай зориулалтын шилжүүлэг	870,716,900.00	870,716,900.00	0.00
Сум хөгжүүлэх сан	92,291,100.00	97,907,246.00	-5,616,146.00
Нөхөн сэргээлтийн сан	6,335,600.00	6,855,600.00	-520,000.00
Зарлага:	1,505,883,800.00	1,399,340,598.00	106,543,202.00
ЗДТГ	279,973,900.00	279,636,469.00	337,431.00
ИТХ	45,414,900.00	45,113,948.00	300,952.00
Сургууль	463,329,900.00	462,263,274.00	1,066,626.00
Цэцэрлэг	119,856,800.00	118,914,360.00	942,440.00
Соёлын төв	53,103,500.00	55,058,478.00	-1,954,978.00
ЭМТ	234,426,700.00	233,710,619.00	716,081.00
Орон нутгийн хөгжлийн сан	86,904,000.00	85,973,650.00	930,350.00
Сум хөгжүүлэх сан	195,849,200.00	110,750,000.00	85,099,200.00
Нөхөн сэргээлтийн сан	27,024,900.00	7,919,800.00	19,105,100.00

2.11. Шилэн дансны мэдээлэл

Мандах сумын Засаг дарга Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар хангалтгүй байна.

ЗГ-ын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан Сум хөгжүүлэх сангийн журмын 3.5.5, 5.2-т заасны дагуу зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй зээлдэгчийн мөнгийг дансанд төвлөрүүлэх арга хэмжээ авах гэсэн зөвлөмжийг өмнөх жилийн санхүүгийн аудитаар өгсөн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Мандах сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн нийт 42.1 сая төгрөгийн зөрчлийн 6.9 хувь болох 2.9 сая төгрөгийн зөрчилд хохирлыг барагдуулах төлбөрийн акт тогтоож, 82.9 хувь болох 35.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 10.2 хувь болох 4.2 сая төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүллээ.

Төрийн аудитын байгууллагаас аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил түүний шийдвэрлэлийн байдлыг дор нэгтгэн үзүүлэв. Үүнд:

(Мянган төгрөг)

№	Байгууллагын ангилал	Илрүүлэлт						Залруулга	
		Зөрчил		Алдаа		Бүгд дүн		Тоо	Дүн
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	ТТЗ	4	10.2			4	10.2	0	0
2	ТШЗ	9	31.9			9	31.9		
3	ТБӨӨААН								
	Дүн	13	42.1			13	42.1	0	0

Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт (сая төгрөг)

Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТТЗ	4	10.2			1	9.1	3	1.1				
2	ТШЗ	9	31.9	1	2.9	1	25.9	7	3.1	0	0	0	0
3	ТБӨААН												
	Дүн	13	42.1	1	2.9	2	35.0	10	4.2	0	0	0	0

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Мандах сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Мандах сумын Засаг дарга 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

Санал дүгнэлтийн хэлбэр (Тоогоор)

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт			Дүн
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	
1	ТШЗ	3	1		4
2	ТБӨААН				
	Дүн	3	1		4

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Мандах сумын Засаг дарга нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

3.1.1. Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

Тайлант хугацаанд Сум хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгийн болон авлагын журнал хөтлөөгүй байна. Зээлдэгчдийн эргэн төлөлтийг өссөн дүнгээр тайлагнасан нь тухайн тайлант хугацааны зээлийн төлөлт, хүү, алдангийн тооцоог харах боломжгүй болгож байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.3. Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ: 4.3.1.анхан шатны баримт бүрдүүлэх;14.3.2.журналд бичих; 14.3.3.дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх 14.3.4.ажил, гүйлгээний мэдээ гаргах гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.1.2. Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

3.1.3. Өгсөн зөвлөмж: Мөнгөн хөрөнгийн журнал, авлагын журнал хөтлөх

3.2.1. Илрүүлэлт: Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа

Нөхөн сэргээлтийн сан дансанд 2018 онд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч 11 ХХК 6.8 сая төгрөгийн барьцаа хөрөнгө байршуулсан ба 3 ХХК байршуулсан 7.9 сая төгрөгийн хөрөнгөө буцаан авсан байна. Орлогыг төсөвт байгууллагын өөрийн орлогоор бүртгэж буцаан өгсөн мөнгийг бараа үйлчилгээний бусад зардалд бүртгэсэн ба үйл ажиллагааны үр дүнг -1064.2 мянган төгрөгөөр тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх" зарчимтай нийцэхгүй байна.

3.2.2. Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

3.2.3. Өгсөн зөвлөмж: Барьцаа хөрөнгийг өр төлбөр дансанд бүртгэх

3.3.1. Илрүүлэлт: Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарлагыг 195.8 сая төгрөгөөр төлөвлөсөн ба үүний оны эхний үлдэгдлээс зарцуулах дүн 103.5 сая төгрөг, НСС-ийн хөрөнгийн зарлагыг 27.0 сая төгрөгөөр төлөвлөсөн ба оны эхний үлдэгдлээс 20.6 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр СХС-ийн эхний үлдэгдлээс 12.8 сая төгрөг, НСС-ийн эхний үлдэгдлээс 1.1 сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална: 5.1.2.төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.3.2. Эрсдэл: Төсвийн төлөвлөлтийг тооцоо судалгаан дээр төлөвлөөгүйгээс тайлан буруу илэрхийлэгдэх

3.3.3. Өгсөн зөвлөмж: СХС, Нөхөн сэргээлтийн сангийн төсвийг тооцоо, судалгаанд үндэслэж төлөвлөх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	546,587,137.14	441,245,238.91
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	158,998,091.79	141,940,187.79
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	158,998,091.79	141,940,187.79
31210	Төгрөг	158,998,091.79	141,940,187.79
31211	Төрийн сангийн харилцах	158,998,091.79	141,940,187.79
33	АВЛАГА	124,084,976.00	137,077,237.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,501,800.00	250,070.00
33500	Бусад авлага	19,872,420.00	13,165,506.00
33510	Байгууллагаас авах авлага	18,547,220.00	13,165,506.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	1,325,200.00	0.00
33600	Зээлийн авлага	102,710,756.00	123,661,661.00
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	102,710,756.00	123,661,661.00
33612	Хувь хүмүүст олгосон зээл	102,710,756.00	123,661,661.00
35	БАРАА МАТЕРИАЛ	252,344,569.35	153,949,814.12
35100	Түүхий эд материал	19,430,379.09	23,918,876.40
35110	Тусгай зориулалттай материал	18,561,760.00	19,095,396.00
35130	Эм боох материал	868,619.09	4,823,480.40
35400	Хангамжийн материал	231,398,990.26	128,515,737.72
35410	Бичиг хэргийн материал	7,243,764.00	5,475,232.00
35420	Аж ахуйн материал	90,562,495.26	85,081,381.72
35430	Сэлбэг хэрэгсэл	166,000.00	1,270,000.00
35440	Түлш, шатах тослох материал	26,076,880.00	23,555,990.00
35450	Барилгын засварын материал	1,724,000.00	0.00
35460	Хүнсний материал	9,856,208.00	13,133,134.00
35470	Бусад хангамжийн материал	95,769,643.00	0.00
35600	Мал амьтад	1,515,200.00	1,515,200.00
36	НӨӨЦИЙН БАРАА	11,159,500.00	8,278,000.00
36600	Бусад нөөц	11,159,500.00	8,278,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,000,463,750.26	3,396,223,405.24
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,000,463,750.26	3,396,223,405.24
39100	Газар	0.00	0.00
39200	Биет хөрөнгө	2,000,101,250.26	3,372,105,405.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,283,927,669.00	2,618,034,243.00

Мандах сумын ТТЗ-ийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

